



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/22.

Мандалговь

Эрдэнэдалай сумын Сургуулийн дотуур
байрны засварын ажил үнэлгээний хороо
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Эрдэнэдалай сумын Сургуулийн дотуур байрны засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Самданцоодол (Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Төрбат (Иргэний төлөөлөл)
Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)
С.Адъяасүрэн (Санхүү төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Самданцоодол)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060100